

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ Дугаар 2025/ 02

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗАРЛАН ХУРАЛДУУЛАХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.7, 62.1.9, 62.1.15 дахь заалт, 64 дугаар зүйл, 65 дугаар зүйлийн 65.3, 65.4 дэх заалт, 67 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ НЬ:**

1. “Мандалговь-Импекс” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2025 оны 4-р сарын 30-ны 15 цагт УБ хот, БЗД, 6-р хороо, Энхтайвны өргөн чөлөө гудамж, 57/7 тоот хаягт байрлалтай ажлын байранд хурлыг товлосугай.
2. Тус ээлжит хурлаар дараах асуудлыг авч хэлэлцсүгэй.
 1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны талаарх болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэх;
 2. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах
 3. 2025 онд шаардагдах төсөв, түүнтэй холбоотойгоор зээл авах тухай
3. Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт №1-ээр баталж, 2025 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэх, “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар”-ыг Хавсралт №2-оор баталж 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээллэх, мөн уг зарыг 2025 оны 04 дүгээр сарын 10-ний өдөр анх мэдээлсэний дагуу дахин хурлын зар хүргэх, Бүртгэлийн өдрийг 4-р сарын 14-р, Саналын хуудас хүлээн авах өдрийг 2025 оны 4-р сарын 22-ны 17 цагаар тасалбар болгон тогтсугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг "Хавсралт 6"-р баталж, 2025 оны 03 дугаар сарын 30-ны дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компанид хүргүүлсүгэй.

“МАНДАЛГОВЬ-ИМПЕКС” ХК

Дундговь аймаг, Сайнцагаан сум,
7-р баг, Нарлаг

5. Хурлыг зохион байгуулах комиссын даргаар ТУЗ-ын дарга О.Мөнх-Эрдэнэ, гишүүдэд Д.Одгэрэл, С.Баярцэцэг нарыг томилсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Ж.Түмэндэлгэр, гишүүнээр Б. Нямцэрэн нарыг томилсугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал авах хуудсыг "Хавсралт 3,4"-р баталсугай.
8. Хурлын дэгийг "Хавсралт 5"-р баталсугай.

ТУЗ-ийн ДАРГА



О.МӨНХ-ЭРДЭНЭ